



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.24 № 3/527

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гааль татварын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Гааль татварын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Гааль татварын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Гааль татварын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Гааль татварын мэдээллийн технологийн төв" УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ГААЛЬ ТАТВАРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Аудитын тайлан

Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас:261663

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Аудитын байгууллагын хаяг:

Латана аудит ХХК
Улаанбаатар хот Баянзүрх
дүүрэг, 26-р хороо, Хүннүгийн
гудамж, Их Монгол Төв, 907
байр, 203 тоот

E mail:
latana.audit@gmail.com

Вэб: www.latanaaudit.com

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан “Латана аудит” ХХК-ын бүрэн эрхийн хүрээнд Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд УАГ-САГ-/2016/106/СТА-ГАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТУГ-ын 2016 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Уг байгууллагын санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Уг байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 03 дугаар сарын 10-наас 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, “Латана аудит” ХХК-ын аудитор Л.Нансалмаа 2017 оны 03 дугаар сарын 10-наас 03 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлан, гэрчилгээг 2017 оны 03 дугаар сарын 24-нд Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТУГ-ын удирдлагад хүргүүлэв.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТУГ-ын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт орсон байна. НББ-н тухай хууль 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс шинэчлэгдэн мөрдөгдсөн.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус байгууллагын дүрмэнд “Гааль татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, түүний техник технологийн хэвийн ажиллагааг хариуцах замаар гааль, татварын албаны үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж иргэн, хуулийн этгээдэд гааль, татварын цахим үйлчилгээг хүргэхэд техник, технологийн дэмжлэг үзүүлэх, гааль, татварын албаны мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг ханган ажиллахтай холбогдсон цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1. “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.” гэж заасны дагуу Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2016 оны үйл ажиллагааг Гааль Татварын Ерөнхий Газрын багцаас санхүүжиж, санхүүжилтийг төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврын хэрэгжилт хэвийн байна.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 7 чиглэлд 33 сорил-ыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаандаа Санхүүгийн тооцоолох компанийн санхүүгийн тайлангийн “Emerald, Интерактив Би Ай” програмыг ашиглаж байна.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед их гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу төрийн сан дахь харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын төсвийн захирагчид 2016 онд улсын төвлөрсөн төсвөөс урсгал зардалд 1,237,402.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 1,237,402.0 мянган төгрөгийн, Засгийн газрын тусгай сангаас урсгал зардалд 561,173.0 төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 561,173.0 төгрөгийн санхүүжилтээ бүрэн авсан. Нийт олгосон санхүүжилтээс 1,774,312.8 мянган төгрөг зарцуулж, 24,257.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

7. Шилэн дансны мэдээлэл:

Тус байгууллага нь shilendans.gov.mn сайтад байгууллагын 2016 оны 4-12 дугаар сарын төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл болон бусад мэдээллийг байршуулсан байна.

8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 26 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 33 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын төсвийн захирагч байгууллагын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1,798,570.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, авлага, өглөгийн тооцоо, цалин хөлс, гэрэл цахилгаан, шагнал, тэтгэмж урамшуулалын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-З/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 67.2 хувийг тус эзэлж байна.

10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад **материаллаг** хэмжээний алдаа илэрээгүй.

11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан алдаа зөрчил илрээгүй. Тухайн байгууллага нь 2016 оны 04 дүгээр сарын 01-нд байгуулагдсан, санхүүгийн тайлангийн эхний жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа, харьцангуй зөрчил, залруулга бага байна.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Шинэ тутам байгуулагдсан байгууллага тул хууль журмын хүрээнд анхаарал татахуйц зөрчил илэрээгүй.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг нарийвчилсан горим хэрэгжүүлж гүйцэтгэх шаардлагатай байна.

Энэ нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох дээрхи асуудлуудыг 2017 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулан нэвтрүүлээгүй, Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг байна. 2017 оны Санхүүгийн тайланд дээрхи зөрчлүүдийг арилгаж, хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Шинэ тутам байгуулагдсан тул өмнөх Санхүүгийн тайланд хийсэн аудит байхгүй.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



“ГААЛЬ ТАТВАРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ” УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Бүртгэлийн бодлого	2
Асуудал 2	
Дотоод хяналт	3

2017 оны 03 дугаар сар 24

Менежментийн захидал

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Латана аудит” ХХК-ын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Бүртгэлийн бодлого

ҮАГ-ын ажиглалт

1. Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТҮГ нь Санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүйгээс НББ-ийн тухай хуулийн 3.1.9, 20.2.2 заалтууд, эрх ба үүрэг батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлээгүй байдал ажиглагдав.

Эрсдэлүүд

- Үндсэн хөрөнгийн элэгдэх хугацаа, элэгдлийн хувийг тодорхойлох боломжгүй;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого тодорхой бус байна

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай болон НББ-ийн тухай хууль, Татварын багц хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд НБББББ-ийг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах;

Төсвийн захирагчийн хариу

- Аудитаар илэрсэн энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн болно.

2017 оны 3 дугаар сарын 24

Асуудал 2: Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

ҮАГ-ын зөвлөмж

2. Гааль Татварын Мэдээллийн Технологийн Төв УТУГ үйл ажиллагааг хянах Дотоод хяналтын систем байхгүй нь НББ-ийн тухай хуулийн 19.1.1, 19.1.2, Төсвийн тухай хуулийн 36.6 заалтууд болон, эрх ба үүрэг батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлээгүй байдал ажиглагдав.

- Төсвийн тухай хуулийн 36.6, болон НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр заалтын дагуу Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Эрсдэлүүд

Төсвийн захирагчийн хариу

- Дотоод хяналтын системгүйгээс төсвийн хөрөнгө хяналтгүй зарцуулагдах,
- Үргүй зардал бий болох эрсдэл дагуулна.

- Аудитаар илэрсэн энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн болно.

Аудит хийгдсэн Санхүүгийн Байдлын Тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	6,856,652.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4,552.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	4,552.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	4,552.00
33	АВЛАГА	0.00	5,722,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	5,722,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	1,130,100.00
35400	Хангамжийн материал	0.00	1,130,100.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	298,000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	832,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	396,589,770.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	396,589,770.78
39200	Биет хөрөнгө	0.00	391,767,727.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	387,739,772.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-49,986,059.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	44,356,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3,174,115.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	15,176,364.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-2,345,034.27
39300	Биет бус хөрөнгө	0.00	4,822,043.54
39301	Програм хангамж	0.00	4,825,413.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,059,981.96
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	1,233,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-176,387.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	403,446,422.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	403,446,422.78
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	403,446,422.78
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	403,446,422.78
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	403,446,422.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	403,446,422.78

Аудит хийгдсэн Үр Дүнгийн Тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,810,943,439.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	12,368,439.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	12,368,439.00
120010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	12,368,439.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,798,575,000.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,798,575,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	1,237,402,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	561,173,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,407,497,016.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,407,497,016.22
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,383,239,357.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	787,288,752.27
210101	Үндсэн цалин	0.00	690,427,217.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	37,059,755.00
210104	Урамшуулал	0.00	59,801,780.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	83,486,798.83
210201	Тэтгэврийн даатгал	0.00	52,172,011.69
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	6,297,960.14
210203	ҮОМШ өвчний даатгал	0.00	7,522,984.04
210204	Ажилгүйдлын даатгал	0.00	1,953,044.91
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	15,540,798.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	61,123,366.13
210301	Гэрэл цахилгаан	0.00	2,983,225.38
210302	Түлш, халаалт	0.00	1,441,551.60
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,393,089.15
210304	Байрны түрээс	0.00	55,305,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	17,022,691.63
210401	Бичиг хэрэг	0.00	5,894,385.00
210402	Тээвэр шатахуун	0.00	3,284,070.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	0.00	6,430,648.63
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,413,588.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,682,650.00
210601	Багаж, техник хэрэгсэл	0.00	1,682,650.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	11,961,330.00
210701	Гадаад албан томилолт	0.00	2,322,650.00
210702	Дотоод албан томилолт	0.00	9,638,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	345,993,294.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	340,056,049.71
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	5,937,245.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	74,680,473.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	336,050.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	0.00	17,602,845.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	0.00	56,741,578.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	24,257,658.89
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	24,257,658.89
261090	УТБ-н татан төвлөрүүлэлт	0.00	24,257,658.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	0.00	403,446,422.78
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	0.00	403,446,422.78

Аудит хийгдсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-08	Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-09	Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	403,446,422.78	0.00	403,446,422.78
4-08	Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-09	Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-01	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	403,446,422.78	0.00	403,446,422.78

Аудит хийгдсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,798,575,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,798,575,000.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,798,575,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,237,402,000.00
131002	Засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	561,173,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,798,570,448.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,798,239,298.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,773,981,639.11
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	800,354,901.58
210101	Үндсэн цалин	0.00	653,447,001.58
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	0.00	40,177,500.00
210104	Урамшуулал	0.00	106,730,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	88,084,949.57
210201	Тэтгэврийн даатгал	0.00	78,246,408.17
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	2,099,406.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1,735,298.10
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	426,077.80
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	5,577,758.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	61,123,366.08
210301	Гэрэл, цахилгаан	0.00	2,983,225.38
210302	Түлш, халаалт	0.00	1,441,552.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,393,088.70
210304	Байрны түрээс	0.00	55,305,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	8,877,933.00
210401	Бичиг хэрэг	0.00	3,984,425.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2,689,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	560,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,643,638.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	346,743,446.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	305,654,446.50
210602	Тавилга	0.00	41,089,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	9,638,680.00
210702	Дотоод албан томилолт	0.00	9,638,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	434,910,117.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	384,910,117.38
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	50,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	24,248,245.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	24,248,245.00
212	ТАТААС	0.00	24,257,658.89
260301	Татаас шилжүүлэг	0.00	24,257,658.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	331,150.00
223001	Бусад хөрөнгө	0.00	331,150.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	4,552.00
87	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
88	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,552.00

2016 оны Төсвийн Гүйцэтгэлийн Тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	1,240,377,000.00	1,798,570,448.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	1,240,377,000.00	1,798,570,448.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	1,240,377,000.00	1,774,312,789.11
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	800,742,500.00	800,354,901.58
210101	Үндсэн цалин	1,444,000,000.00	73,107,920,091.60	653,834,600.00	653,447,001.58
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	110,908,400.00	1,499,464,060.00	40,177,500.00	40,177,500.00
210104	Урамшуулал	310,435,200.00	3,808,382,417.10	106,730,400.00	106,730,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	88,085,100.00	88,084,949.57
210201	Тэтгэврийн даатгал	130,574,100.00	1,740,033,813.80	78,246,558.60	78,246,408.17
210202	Тэтгэмжийн даатгал	14,922,700.00	0.00	2,099,406.93	2,099,406.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,653,400.00	0.00	1,735,298.10	1,735,298.10
210204	Ажилгүйдлийн даатгал	3,730,700.00	0.00	426,077.80	426,077.80
210205	Эрүүл мэндийн даатгал	37,306,900.00	0.00	5,577,758.57	5,577,758.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	83,371,200.00	61,123,366.08
210301	Гэрэл, цахилгаан	59,483,100.00	584,271,837.00	1,800,000.00	2,983,225.38
210302	Түлш, халаалт	43,421,900.00	105,595,086.00	2,100,000.00	1,441,552.00
210303	Цэвэр, бохир ус	13,464,000.00	40,222,928.52	1,300,000.00	1,393,088.70
210304	Байрны түрээс	0.00	0.00	78,171,200.00	55,305,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	8,862,200.00	8,877,933.00
210401	Бичиг хэрэг	31,440,000.00	1,066,067,730.00	4,330,500.00	3,984,425.00
210402	Тээвэр, шатахуун	10,550,000.00	185,378,232.00	2,796,500.00	2,689,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	123,428,100.00	650,971,449.44	467,800.00	560,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,820,000.00	247,449,008.00	1,267,400.00	1,643,638.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	47,089,000.00	347,074,596.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	212,000,000.00	6,995,231,430.00	6,000,000.00	305,985,596.50
210602	Тавилга	5,000,000.00	994,960.00	41,089,000.00	41,089,000.00
2107	Томиллолт, зочны зардал	0.00	0.00	13,034,800.00	9,638,680.00
210702	Дотоод албан томилолт	52,249,900.00	252,753,057.60	13,034,800.00	9,638,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	174,942,400.00	434,910,117.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,900,000.00	33,815,325,042.40	124,942,400.00	384,910,117.38
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	418,830,000.00	4,849,892,160.00	50,000,000.00	50,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	24,249,800.00	24,248,245.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	100,000,000.00	980,034,750.00	24,249,800.00	24,248,245.00
212	ТАТААС	0.00	0.00	0.00	24,257,658.89
260301	Тагаас шилжүүлэг	0.00	1,277,387,954.75	0.00	24,257,658.89
15	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	0.00	0.00	0.00	1,798,575,000.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00	0.00	1,798,575,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00	0.00	1,237,402,000.00
131002	Засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	0.00	0.00	561,173,000.00
3	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00	-1,240,377,000.00	4,552.00
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
175	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	4,552.00

2016 оны нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	561,173,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	561,173,000.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	561,173,000.00
131002	Засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	561,173,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	561,089,844.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	561,089,844.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	561,089,844.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	299,993,596.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	299,993,596.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	261,096,248.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	261,096,248.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	83,155.50